# НИЙСЛЭЛИЙН

# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН

# ТОГТООЛ

2025 оны 01 сарын 27 өдөр Дугаар 25/01 Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр

нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалт

батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Төр хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралтаар батлсугай.

2.Батлагдсан жагсаалтад туссан түншлэлийн төслүүдийн бүрэн шинжилгээг хийж, холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА А.БАЯР

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
25/01 дүгээр тогтоолын хавсралт

## НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТОД ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ

## ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

| № | Төслийн нэр | Тайлбар /хүчин чадал, хэмжээ/ | Хэрэгжих хугацаа | Гэрээний нөхцөл, санхүүжилт |
|---|---|---|---|---|
| 1 | "УБ Метро"<br><br>(1,2-р шугам) төсөл | Яармаг-Амгалан хүртэл нийт 17.7 км урт тусгай шугам,<br><br>14 байршилд өртөө байгуулна. Өртөө хоорондын зай 1.3 км, аяллын дундаж хугацаа 27 минут, дундаж хурд 39.2 км/цаг. | "Шугам 1"-2024-2030<br><br>"Шугам 2"-2025-2032 | Түлхүүр гардуулах нөхцөл +Хөрөнгө оруулалт<br><br>(EPC+F+ Availability Payment) |
| 2 | “УБ Трамвай”<br><br>(1,2-р шугам) төсөл | Замын нийт 10.2 км,<br><br>23 буудалтай, буудал хоорондын зай 500-700 метр. | 2025-2027 | Түлхүүр гардуулах нөхцөл (EPC) |
| 3 | "Шинэ тойрог зам"<br><br>(1,2-р тойрог) төсөл | Нийт 68.4 км,<br><br>Дотор тойрог зам 13.4км,<br><br>Гадна тойрог зам 55 км, | 2027-2032 | Түлхүүр гардуулах нөхцөл + Хөрөнгө оруулалт<br><br>(EPC + F + Availability Payment) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Зорчих эгнээ 4-6. | | |
| 4 | "Туул хурдны зам" төсөл | Нийт замын урт 32км,<br><br>Зорчих хэсэг 3.5*4 эгнээ,<br><br>Төмөр бетон гүүр 875 м,<br><br>Орох гарах уулзвар. | 2025-2027 | Барилга угсралтын тендер + F + Availability Payment<br>3 багц (10км+ 8км+14км) |
| 5 | "Тусгай замын автобус" (BRT) төсөл | “Ард Аюушийн өргөн чөлөө-Их тойруу-Намъянжүгийн гудамж-Нийслэл хүрээ өргөн чөлөө болон Сүхбаатарын талбайн төв зогсоол,<br><br>Их тойруугийн өргөн чөлөө”-ний дагуу нийт 11.9 км ба 17 зогсоолыг төлөвлөсөн. | 2025-2027 | Азийн хөгжлийн банкны батлагдсан зээлээр |
| 6 | "Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүр | Нийт 1230м урт, 4 ширхэг 35м өндөр бүхий ган татлага цамхагтай Туулын хурдны замтай 6 ширхэг налуу рампаар холбогдоно. | 2025-2028 | Түлхүүр гардуулах нөхцөл + Хөрөнгө оруулалт<br><br>(EPC + F + Availability Payment) |
| 7 | “Олон түвшний уулзвар” төсөл | Нийт 13км урт авто замыг олон түвшинтэй болгох ажил хийгдэнэ. | 2025-2027 | Нийслэлийн төсөв |
| 8 | "Дүүжин замын тээвэр" төсөл (1,2-р шугам) | "шугам 1" урт -4.2 км,<br><br>"шугам 2" урт -2.7 км. | 2025-2027 | Францын Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээл, нийслэлийн төсөв |
| 9 | "Хөшгийн хөндийн салбар төмөр зам" төсөл | Техникийн үндсэн үзүүлэлтүүд:<br>Гол замын урт – 102 км<br>Голын даац – 25 тонн<br>Удирдах хэвгий - 9‰<br>Хамгийн бага радиус – 600 метр<br>Цариг - 1520мм<br>Галт тэрэгний хурд – 120 км/цаг<br>Гүүрэн байгууламж – 5 км/урт<br>Ус зайлуулах хоолой – 95 ширхэг | 2025.01-08 | Түлхүүр гардуулах нөхцөл + Хөрөнгө оруулалт<br><br>(EPC + F + Availability Payment) |
| 10 | “ТЭЦ-5” төсөл | Дулааны II цахилгаан станц Сонгинохайрхан дүүргийн Таван шар, Нефть, 21-р хорооллын бүсийг хангадаг бөгөөд суурилагдсан хүчин чадал 60 Гкал/ц, холбогдсон тооцоот ачаалал 97.6 Гкал/ц болж ачаалал хэтэрсэн. Шинэчлэлтийн ажлын хүрээнд 2Ø700мм голчтой 130 хос метр шугамыг өргөтгөнө. | 2025-2028 | Барих, ашиглах, шилжүүлэх<br><br>(BOT нөхцөл Хот хувь эзэмшинэ) Хэлэлцээр хийж, гэрээ байгуулах (ХХГБ) Дагалдах дэд бүтэц- ТЭЦ-2 төмөр зам, шугам хоолойг ашиглана. |
| 11 | “Тархмал эрчим хүчний эх үүсвэр” төсөл | Нийт 100 мянган өрхийг хийн түлшээр хангах хүчин чадалтай шингэрүүлсэн хийн түгээх станц 4 байршилд,<br><br>Хийн эх үүсвэртэй дулааны өргөх станц 4 байршилд, шингэрүүлсэн хийгээр ажилладаг<br><br>дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх 24 МВт 1 станц, хатуу түлшээр ажилладаг 5 станц. | 2025-2030 | Түлхүүр гардуулах нөхцөл + Хөрөнгө оруулалт<br><br>эсхүл Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд<br><br>(EPC + F + Availability Payment эсхүл BOT) |
| 12 | “Сэлбэ хот орон сууцжуулах” төсөл | Орон сууцны 12.000 айл, талбай 162 га. | 2025-2027 | Гадаад бонд,<br><br>Барилга угсралтын гэрээ,<br>Нээлттэй тендер |
| 13 | “Баянхошуу орон сууцжуулах” төсөл<br><br>(1,2-р үе шат) | Ногоон орон сууц 5000 айл,<br><br>Үе шат 1-800 айл , талбай 45 га,<br><br>Үе шат 2- 4200 айл. | үе шат 1<br><br>2023 – 2026<br>үе шат 2<br><br>2025 – 2028 | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл |
| 14 | "Ханын материал орон сууцжуулах" төсөл | Орон сууц 3000 айл, талбай 9.7 га. | 2025-2027 | Төр, хувийн хэвшлийн түншлэл (барилга угсралт санал авна эсхүл EPC+F+Availability payment) борлуулалтыг хот хариуцна. |
| 15 | "Хог шатааж эрчим хүч гаргах үйлдвэр" төсөл | Морингийн даваа болон Цагаан давааны хогийн цэгт 300-400 мян.тонн хог шатааж, 34 мвт эрчим хүч үйлдвэрлэнэ. | Морингийн даваа<br><br>2025-2028<br>Цагаан даваа<br><br>2025-2028 | Барих, ашиглах, шилжүүлэх (BOT) Хэлэлцээр хийж, гэрээ байгуулах (ХХГБ) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 16 | "Шинэ цэнгэлдэх хүрээлэн" төсөл | Нийт 30,000 суудалтай,<br><br>Дэд арена- 10,000 суудалтай,<br><br>Талбай 14.5 га | 2025-2028 | Барих, ашиглах, шилжүүлэх (BOT)<br>Хот хувь эзэмшинэ. |
| 17 | "Туул усан цогцолбор" төсөл | Туул голын урсцад тохируулга хийх замаар Улаанбаатар хотын ус хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор хотын ус хангамжийн эх үүсвэр 25 хувь буюу хоногт гадаргын 125,000м3 ус хуримтлуулах эх үүсвэр барина. | 2026-2028 | Улс нийслэлийн төсөв, Гадаадын зээл, тусламж |
| 18 | "Шинэ Зуунмод хотын дэд бүтэц" төсөл | 31.500 га, цахилгааны чадал 250 мвт,<br>Дулааны чадал 465 мвт,<br><br>(цахилгаан дулааны бүхий л эх үүсвэр ашиглана)<br>Ариутгах татуурга 20000М3 хоног,<br><br>Авто зам 128.5км | 2025-2027 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх төрлийн загвар нээлттэй |
| 19 | "Хөрсний ус үерийн хамгаалалт" төсөл | Үерийн эрсдэлийн хохирлын үнэлгээг боловсруулж, голуудын эргийн хамгаалалтын 30 км далан, 100 км суваг, 4 байршилд усан сан, хөв, цөөрөм, 20 км, хөрсний усны шугам сүлжээг барьж байгуулна. | 2025-2028 | Улс нийслэлийн төсөв, Гадаадын зээл, тусламж |
| 20 | "Лаг шатаах үйлдвэр" төсөл | Хоногт 250 м3 хүчин чадал лагийг хатаан, шатааж 5-6 м3 үнс болгоно,<br><br>Нийт лагийн хэмжээ 843,200 м3 (хаягдмал нөөцтэй). | 2025-2028 | Түлхүүр гардуулах нөхцөл + Хөрөнгө оруулалт<br><br>(EPC + F + Availability Payment эсхүл EPC) гүйцэтгэгч шалгаруулах |
| 21 | "Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц" төсөл | Нийт 539 га талбайд 24 МВт дулааны цахилгаан станц дагалдах барилга байгууламжийн хамт, 8000м3/хоног ахуйн болон үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламж,<br><br>12км гадна цэвэр усны шугам, 13 км гадна хотын зэрэглэлтэй авто зам, паркийн доторх инженерийн шугам сүлжээ,<br><br>7 км үерийн хамгаалалтын барилга байгууламж, хог хаягдлыг ангилах, шатаах иж бүрэн байгууламж. | 2025-2027 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх төрлийн загвар нээлттэй |
| 22 | "ОУ-ын Зочид буудал" төсөл | 300 өрөөтэй, Талбайн хэмжээ 13,790 м2. | 2026-2028 | ТХХТ,<br>Хэлэлцээр хийж, гэрээ байгуулах (ХХГБ)<br><br>УБ хот + Барилгын хөрөнгө оруулагч + Ашиглагч Marriott сүлжээ – 3 талт |
| 23 | "Баруун далай Орд" төсөл | 300Мвт, ЦДАШ 120 км, 220кВт шугам. | 2025-2027 | Барих, ашиглах, шилжүүлэх (BOT) |
| 24 | "Улаанбаатар хотын такси үйлчилгээг сайжруулах нь" төсөл | Таксины парк шинэчлэл 3000 ширхэг цахилгаан болон хосолмол хөдөлгүүртэй автомашин, Хөрөнгө оруулалтын хэмжээ - 100 тэрбум, | 2025-2032 | Төр, хувийн хэвшлийн түншлэл |
| 25 | "Нийтийн тээврийн төлбөр тооцооны менежментийн систем нэвтрүүлэх" төсөл | Нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй автобусны картын системийг шинэчлэх, Биет карт худалдан борлуулах, цэнэглэх 100 ширхэг (эхний ээлжид) киоск төхөөрөмж байршуулах, автобусны буудлууд дээр автобусны чиглэл холбогдох мэдээллийг харуулах зориулалт бүхий 100 ширхэг лед дэлгэц (эхний ээлжид) байршуулна. | 2025-2028 | Төр, хувийн хэвшлийн түншлэл<br>Хэлэлцээр хийж, гэрээ байгуулах (ХХГБ) |
| 26 | "УБ ЧАТ сошиал болон төлбөр тооцооны нэгдсэн систем" төсөл | +2 их наяд гүйлгээний дүн +100 сая гүйлгээний тоо +650 үйлчилгээ 1 сая гаруй хэрэглэгч | 2025-2028 | Төр, хувийн хэвшлийн түншлэл<br>Хэлэлцээр хийж, гэрээ байгуулах (ХХГБ) |
| 27 | "Хүнс хангамж төв ОНӨААТҮГ"-ын оффисын барилга угсралтын ажил<br><br>/СХД, 2 дугаар хороо/ | Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг эрүүл, аюулгүй, стандарт шаардлага хангасан, баталгаатай чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах зориулалтын 2 давхар 601.6м2 талбайтай барилга байна. | 2025-2026 | Төр, хувийн хэвшлийн түншлэл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 28 | "Асгат" ОНӨААТҮГ-ын сургууль, цэцэрлэгийн хүнсний хангамжийн агуулахын барилга угсралтын ажил<br><br>/БГД, 18-р хороо/ | Ерөнхий шаардлага MNS 5064:2011 стандартад нийцсэн оффис, хүнсний агуулахын зориулалттай 24,8х21 м2 бүхий 2 давхар барилга, худалдааны агуулахын барилга угсралтын ажлыг хэрэгжүүлнэ. | 2025-2027 | Төр, хувийн хэвшлийн түншлэл |
| 29 | "Орлогод нийцсэн орон сууцны төслийн гадна инженерийн шугам сүлжээ"-ний ажил<br><br>/СХД, 24-р хороо/ | Нийт 840 айлын орон сууц, 320 хүүхдийн сургууль, 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгажилтын төслийн гадна инженерийн шугам сүлжээний найдвартай эх үүсвэр бий болно. | 2025-2027 | Төр, хувийн хэвшлийн түншлэл |
| 30 | "Улаанбаатар хотын төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, махны хадгалалт, борлуулалтын цогцолбор" төсөл | Хадгалалтын хүчин чадал 20,0 мянган тонн бүтээгдэхүүн хүлээн авна. Жилдээ 90,0-100,0 мянган тонн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах хадгалж борлуулна. | 2025-2027 | Төр, хувийн хэвшлийн түншлэл Хэлэлцээр хийж, гэрээ байгуулах (ХХГБ) |
| 31 | "Нийслэлийн мал эмнэлгийн газрын оффис, лабораторийн барилга" төсөл | Нийслэлийн Мал эмнэлгийн газрын зориулалтын лаборатори, оффис, зоорь бүхий 5 давхар барилга барина.<br><br>Лаборатори байгуулсны үр дүнд амьд вакцин, омог, ийлдэс хадгалах зориулалтын хөргүүр бүхий өрөө тасалгаатай болж, агуулах, складын хүрэлцээ бий болж чанартай үйлчилгээтэй шинжилгээ хийгддэг болно. | 2026-2028 | Төр, хувийн хэвшлийн түншлэл |
| 32 | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 20 дугаар хороонд 10 мянган хүн оршин суух "Аялал жуулчлалын Эко хот" байгуулах төсөл | 6830га тусгай хэрэгцээтэй газарт нийтийн зориулалттай орон сууцны хороолол барих. | 2025-2032 | Төр, хувийн хэвшлийн түншлэл |
| 33 | "Батериа хуримтлуурын станц" төсөл | 10МВт буюу 42,000 Квт цагаар бууруулах | 2025-2027 | Төр, хувийн хэвшлийн түншлэл Хэлэлцээр хийж, гэрээ байгуулах (ХХГБ) |